МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 09 сарын 15 өдөр Дугаар А/336 Улаанбаатар хот

Импортын бүртгэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэг, Хүний эмийн зөвлөлийн 2023 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Фарм трейд” ХХК-д импортын лиценз олгох эмийн жагсаалтыг нэгдүгээр, “Аглаг Мед” ХХК-д импортын лиценз олгох эмийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2. Хумхаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, эмийн бүртгэл, лиценз олголт, эмийн чанар аюулгүй байдлын талаар Батлан хамгаалах яам болон импортлогч байгууллагуудад мэргэжлийн арга зүй зөвлөгөө өгч хамтран ажиллахыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт даалгасугай.

3. Импортолсон эм, вакцины чанар, аюулгүй байдлыг бүрэн хариуцаж, импортлох үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж, холбогдох байгууллагыг эмээр тасралтгүй, жигд хангаж ажиллахыг Эм ханган нийлүүлэх байгууллагад үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (С.Төгсдэлгэр) - д даалгасугай.

САЙД С.ЧИНЗОРИГ

141224445

Эрүүл мэндийн сайдын
2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн
А/336 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

# ФАРМ ТРЕЙД ХХК-Д ИМПОРТЫН ЛИЦЕНЗ ОЛГОХ ЭМИЙН ЖАГСААЛТ

| Д/Д | Олон улсын нэр | Худалдааны нэр | Тун хэмжээ | Эмийн хэлбэр | Тоо хэмжээ | Үйлдвэрлэгчийн нэр | Улс |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Мефлохин гидрохлорид | Мефто 250мг | 250мг №40 | шахмал | 1410 хайрцаг | Arvincare Group India (Sunvet pharmaceuticals) | Энэтхэг |

Эрүүл мэндийн сайдын
2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн
A/336 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

## АГЛАГ МЕД ХХК-Д ИМПОРТЫН ЛИЦЕНЗ ОЛГОХ ВАКЦИНЫ ЖАГСААЛТ

| Д/Д | Олон улсын нэр | Худалдааны нэр | Тун хэмжээ | Эмийн хэлбэр | Тоо хэмжээ | Үйлдвэрлэгчийн нэр | Улс |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Тарваган тахлын амьд хуурай вакцин Вакцина чумная живая, лиофилизат для приготовления суспензии для инъекций, накожного скарификационного нанесения и ингаляций | Тарваган тахлын амьд хуурай вакцин | 1ампулд 156 арьсан дор тарих тун | Тарилгын уусмал бэлтгэх нунтаг | 36 хайрцаг №10 | ФКУЗ Ставропольский Научно Исследовательский Противочумнои Институт | ОХУ |